


Таны

ХУВИЙН  
МЭДЭЭЛЭЛ

ТАНЫ

МЧ





ТУНГААХУЙ ӨГӨГДЛИЙН УРЛАН  
[www.tungaahui.mn](http://www.tungaahui.mn)  
[@tungaahui](https://www.instagram.com/tungaahui)

© Тунгаахуй өгөгдлийн урлан ХХК, 2026



Энэхүү гарын авлагыг зохиогчийг дурдах нөхцөлтэйгээр бүтнээр болон хэсэгчлэн чөлөөтэй ашиглах, хуулах, нийтлэх, түгээх боломжтой.

# ТАНЫ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ТАНЫ ӨМЧ

ХӨТӨЧ

УЛААНБААТАР | 2026


# ТА ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ХАМГААЛАХ ТУХАЙ БОДОЖ БАЙСАН УУ?

Бид өдөр тутмын амьдралгаа үйлчилгээ авах, аппликейшн ашиглах, онлайн худалдан авалт хийх, сошиал орчинд пост нийтлэх зэрэг олон үйлдлээр өөрсдийн мэдээллийг байнга хуваалцаж байдаг.

Бидний хуваалцдаг зарим мэдээлэл бидний **хэн болохыг таних, тодорхойлох** боломж олгодог учраас хувийн мэдээлэлд тооцогддог. Жишээ нь, таны нэр, регистрийн дугаар, байршил, банкны мэдээлэл зэрэг нь таны хувийн мэдээлэл юм.

Хувийн мэдээлээ хуваалцах нь өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг боловч мэдээлээ хэнд, ямар зорилгоор өгч байгааг анхаарахгүй байх нь таны хувийн орон зай, аюулгүй байдалг **эрсдэл** үүсгэж болзошгүй.

Технологийн хөгжил, цахим хэрэглээ нэмэгдэхийн хэрээр бидний үлдээдэг **өгөгдлийн ул мөр** улам их болж байна. Тиймээс хувийн мэдээлээ ойлгох, ямар мэдээлээ хаана, хэрхэн хуваалцах, хамгаалах талаар мэдлэгтэй байх нь чухал юм.




## “ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ” ГЭХ ОЙЛГОЛТ ХААНААС ЭХЛЭЛТЭЙ ВЭ?

“Хувийн мэдээлэл” гэх ойлголт нь хүний нууц, хувийн орон зайг хамгаалах хэрэгцээнээс үүсэлтэй ч өнөөдрийнх шиг өргөн утгаар ойлгогдох болсон нь технологийн хөгжилтэй салшгүй холбоотой.




XIX зууны сүүлээр сонин хэвлэл, гэрэл зураг эрчимтэй хөгжиж эхлэхэд хүмүүсийн хувийн амьдралыг зөвшөөрөлгүй олон нийтэд ил болгох явдал нэмэгджээ. Үүнээс үүдэн **“privacy”** буюу хувийн нууцын тухай хөндөж эхэлсэн.

1890 онд Америкийн хуульч Самуэл Д. Уоррен, Луис Брандейс нар “Хувийн нууцын эрх” (The Right to Privacy) нэртэй өгүүлэл бичиж, хүний хувийн амьдрал, мэдээлэл олон нийтийн өмч биш гэсэн санааг дэвшүүлсэн нь орчин үеийн хувийн мэдээлэл хамгаалах үзлийн эхлэл болсон гэж үздэг.



Гэвч жинхэнэ эргэлт XX зуунд компьютер бий болсноор эхэлсэн. Өмнө нь хүний мэдээлэл ихэвчлэн цаасан хэлбэрээр хадгалагддаг, түгэх хүрээ бага, хайж ашиглах боломж хязгаарлагдмал байсан бол компьютер, интернет хөгжсөнөөр мэдээллийг асар их хэмжээгээр цуглуулах, хадгалах, боловсруулах боломж бий болсон.

Үүнийг дагаад хувийн мэдээлэл алдагдах, зөвшөөрөлгүй ашиглагдах аливаа эрсдэлүүд ч нэмэгдсэн. Улмаар **хувийн мэдээлэл хамгаалах хууль, эрх зүйн зохицуулалтууд** хөгжиж эхэлжээ.



1948 онд НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалд **хүний хувийн нууцыг хамгаалах нь хүний үндсэн эрхийн нэг** болохыг хүлээн зөвшөөрсөн бол 1970-аад оноос улс орнууд мэдээлэл хамгаалах анхны хуулиудаа баталж эхэлсэн байна.

Өнөөдөр хувийн мэдээлэл нь хүний хувийн орон зай, аюулгүй байдал, эрх чөлөөтэй холбоотой хүний эрхийн чухал асуудлын нэг болоод байна.

# ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ “ХУУЛИАР” ХАМГААЛАГДАХ БОЛСОН НЬ

ОЛОН УЛСАД

1948

• **Хувийн нууцыг хүний эрх гэж хүлээн зөвшөөрөв.**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүний хувийн нууцыг хамгаалах нь хүний үндсэн эрхийн нэг гэж тунхагласан.

1970

• **Мэдээлэл хамгаалах анхны хуулиуг гарч эхлэв.**

Германы Хессен мужид дэлхийн анхны мэдээлэл хамгаалах хуулиудын нэг батлагдсан.

1980

• **Хувийн мэдээлэл ашиглах зарчим бий болов.**

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) хувийн мэдээллийг хэрхэн цуглуулах, ашиглах, хамгаалах үндсэн зарчмуудыг тодорхойлсон удирдамж гаргасан.

1995

• **Европ хувийн мэдээлэл хамгаалах нийтлэг стандарттай болов.**

Европын холбоо “Өгөгдөл хамгаалах удирдамж” (Data Protection Directive) баталж, хүний хувийн мэдээллийг хамгаалах, мэдээллийг зөвхөн тодорхой зорилгоор ашиглах зарчмыг нэвтрүүлсэн.

2018

• **Хувийн мэдээлэл хамгаалах орчин үеийн хамгийн хүчтэй зохицуулалт - GDPR**

Европын холбооны “Мэдээлэл хамгаалах ерөнхий журам” (General Data Protection Regulation) хэрэгжиж эхэлснээр ирээд өөрийн хувийн мэдээлэлдээ илүү хяналттай байх нөхцөл бүрдсэн. Байгууллагууд мэдээлэл цуглуулахдаа зөвшөөрөл авах, хувийн мэдээлэл хамгаалах үүрэгтэй болсон бөгөөд ирээд мэдээлэлээ харах, засах, устгуулах эрхтэй болсон.

2024

• **Хиймэл оюун ухаан ба хувийн мэдээлэл**

Европын холбоо Хиймэл оюун ухааны тухай хууль (Artificial Intelligence Act)-ийг баталж, хиймэл оюун ухааны (AI) системүүд хүний хувийн мэдээлэл, нүүр таних технологийг хэрхэн ашиглахыг зохицуулж эхэлсэн.

# ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ “ХУУЛИАР” ХАМГААЛАГДАХ БОЛСОН НЬ

МОНГОЛ УЛСАД

1992

**Монгол Улсын Үндсэн хууль**

Монгол Улсын Үндсэн хуульд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг баталгаажуулж, иргэний хувийн амьдрал, захидал харилцаа, орон байрны нууцыг хуулиар хамгаална гэж заасан.

1995

**Хувь хүний нууцын тухай хууль (хүчингүй болсон)**

Иргэний хувийн нууцыг хамгаалах анхны тусгайлсан хууль батлагдав.

2011

**Мэдээллийн ил тог байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (хүчингүй болсон)**

Төрийн мэдээллийг нээлттэй болгохын зэрэгцээ иргэний хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалтыг тусгав.

2021

**Хувийн мэдээлэл хамгаалах шинэ үе**

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тэргүүтэй багц хуулиуд батлагдсанаар хүний хувийн мэдээллийг хамгаалах эрх зүйн орчин шинэ шатанг гарч, иргэд өөрийн мэдээлэлдээ илүү хяналттай байх, хамгаалуулах нөхцөл бүрдсэн.

# ТАНЫ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ

## ТАНЫ “ӨМЧ”

Таныг шууд болон шууд бусаар **тодорхойлох**, **таных** боломжтой аливаа мэдээлэл таны хувийн мэдээлэлд тооцогдоно.



Бидний өдөр тутам хуваалцдаг олон зүйл **“хувийн мэдээлэл”** байдаг. Зарим мэдээлэл гангаараа таныг хэн гэдгийг шууд тодорхойлох боломжгүй ч бусад мэдээлэлтэй нийлж таныг таных боломжтой.

**Жишээ нь**, тодорхой байгууллагад ажилладаг, 28 настай, эрэгтэй гэх мэт мэдээллүүд нийлбэл нэр байхгүй байсан ч тухайн хүнийг таных боломж үүсэж болно.

Таны хувийн мэдээлэл бол таны өмч.

Таны зөвшөөрөлгүйгээр хэн ч таны хувийн мэдээллийг ашиглах ёсгүй.

Хувийн мэдээлэл нь **таныг таных** боломж олгодог тул буруу зорилгоор ашиглагдах **эрсдэл** үүсдэг.




Таны хувийн мэдээллийн аюулгүй байдал, хамгаалуулах эрх нь Монгол Улсын Иргэний хуульд заасан **“халдашгүй байх эрх”** болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан **“хувийн мэдээллээ хамгаалуулах эрх”**-ээр хуульчлан баталгаажсан.

# ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛД ЯМАР МЭДЭЭЛМҮҮД БАГТАХ ВЭ?



# ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ

Хүнийг шууд эсвэл шууд бусаар таних боломжтой аливаа мэдээлэл.



нэвтрэх нэр,  
цахим шуудан,  
сошиал хаяг,  
хайлтын түүх  
гэх мэт

Цахим орчинд таныг таних боломжтой мэдээлэл

# ХҮНИЙ ЭМЗЭГ МЭДЭЭЛЭЛ

Алдагдах эсвэл зөвшөөрөлгүй ашиглагдах тохиолдолд хүний эрх, аюулгүй байдал, нэр хүндэд эрсдэл учруулж болох мэдээлэл.

Хүний нууц мэдээлэл

Үндэс угсаа

Шашин шүтлэг

Итгэл үнэмшил

Ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх

# ХҮНИЙ НУУЦ МЭДЭЭЛЭЛ

Бусдад заруулахгүй хамгаалах ёстой мэдээлэл.

имэйл, шуудан, илгээмж, чат, мессеж, дуудлага, файл, зураг, видео илгээсэн түүх

Захидал харилцааны мэдээлэл

Эрүүл мэндийн мэдээлэл

өвчний түүх, онош, шинжилгээний харуу, эрүүл мэндийн үйлчилгээ авсан тухай мэдээлэл

хурууны хээ, нүүр царай, нүдний солонгон бүрхэвч, гуу хоолой, алхаа, хөдөлгөөний хэв маяг зэрэг биеийн давхцахгүй өгөгдөл

Биометрик мэдээлэл

хүний ДНХ, удамшил, биологийн онцлогтой холбоотой дахин гавтагддаггүй мэдээлэл

Генетик мэдээлэл

Бэлгийн харьцааны талаарх мэдээлэл

Бэлгийн болон хүйсийн чиг баримжаа

Тоон гарын үсгийн хувийн түлхүүр

# ЭНЭ Ч БАС ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ҮҮ?



АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЕЭР  
АВАГДСАН ФОТО ЗУРАГ

Хүнийг шууд тодорхойлох  
боломжтой бол хувийн мэдээлэл



ДУУ ХООЛОЙ / VOICE  
MESSAGE

Хүний нууц мэдээлэл / Биометрик мэдээлэл



ГАРЫН ХУРУУНЫ ХЭЭ

Хүний нууц мэдээлэл / Биометрик мэдээлэл



ЦАРАЙ ТАНИХ СИСТЕМАД  
АШИГЛАЖ БУЙ ЗУРАГ

Хүний нууц мэдээлэл / Биометрик  
мэдээлэл



ЦАЛИНГИЙН  
МЭДЭЭЛЭЛ

Хүний хувийн мэдээлэл / Хөрөнгийн  
мэдээлэл



ЭМНЭЛГИЙН ЦАГ АВСАН  
МЭДЭЭЛЭЛ

Хүний нууц мэдээлэл / Эрүүл мэндийн мэдээлэл



АВТОБУСНЫ КАРТАНД  
БҮРТГЭГДСЭН ЗОРЧИЛТЫН  
ТҮҮХ

Хүний хувийн мэдээлэл



ИМЭЙЛ, ЧАТ

Хүний нууц мэдээлэл / Захирал  
харилцааны мэдээлэл



ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХНИЙ  
ХУУЛБАР

Хүний хувийн мэдээлэл



ҮНДЭС УГСААНЫ ТУХАЙ  
МЭДЭЭЛЭЛ

Хүний эмзэг мэдээлэл



INSTAGRAM  
ХАЙЛТЫН ТҮҮХ

Хүний хувийн мэдээлэл / Цохиу тодорхойлогч



ОРЦНЫ КАМЕРЫН  
БИЧЛЭГТ ҮЛДСЭН ДҮРС

Хүний нууц мэдээлэл / Биометрик мэдээлэл



ХООЛ ХҮРГҮҮЛСЭН  
ХАЯГИЙН МЭДЭЭЛЭЛ

Хүний хувийн мэдээлэл


# БИДНИЙ ҮЛДЭЭДЭГ ӨГӨГДЛИЙН УЛ МӨР

Бид өдөр тутмын энгийн үйлдлээрээ хувийн мэдээллээ хуваалцаж байдаг.

Үйлчилгээ авах, төлбөр тооцоо хийх, нийгмийн харилцаанд оролцох, цахим платформ ашиглах зэрэг өдөр тутмын үйл ажиллагааны явцад хувийн мэдээллээ хуваалцах шаардлага үүсдэг.

## Өглөө

Ухаалаг утас, цаг, аппликейшн – унтсан хугацаа, сэрсэн цаг, зүрхний хэм, байршил



## Сошиал медиа ашиглах

- Пост, сторн
- Like, share, comment
- Хайлтын түүх
- Чат, voice message



## Ажил, сургууль дээр

- Ирц бүртгэл
- Камерын бичлэг
- Имэйл, гомоог чат
- Онлайн хурал, хичээлийн мэдээлэл
- Цалин, төлбөрийн мэдээлэл
- Гүйцэтгэлийн үнэлгээ, дүн
- Амралт, чөлөөний бүртгэл

## Үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэх, цаг захиалах

- Нэр
- Регистрийн дугаар
- Хаяг
- Утас
- Имэйл хаяг
- Зураг
- Захиалгын түүх
- Үйлчилгээний түүх
- Төлбөрийн мэдээлэл

## Онлайн худалдан авалт, хүргэлтийн үйлчилгээ авах

- Нэр
- Хаяг
- Утас
- Төлбөрийн мэдээлэл
- Худалдан авалтын түүх
- Таалагдсан барааны жагсаалт



## Энтертайнмент (Youtube, Netflix, Spotify гэх мэт)

- Үзсэн контент
- Хайлтын түүх
- Игэвхтэй байсан цаг
- Ашигласан төхөөрөмж



## Орой

- Өдрийн алхалтын тоо
- Унтахын өмнөх дэлгэцийн хэрэглээ
- Сэрүүлэг
- Унтсан цаг

## Таны хувийн мэдээллүүд нийлсээр

Та хэн бэ?

Та сонирхол, сонголт

Таны хүрээлэл, харилцаа

Таны амьдралын хэв маяг, зуршил

Таны эрүүл мэндийн байдал

Таны орлого, зардал

Таны үзэл бодол


зэрэг таны тухай дэлгэрэнгүй “дүр зураг” гаргах боломжтой.

## Гэрээс гараад

- Google Maps – байршил, маршрут, тээврийн хэрэглээ
- Автобусны карт, таксины аппликейшн – байршил, маршрут, төлбөрийн мэдээлэл
- Дэлгүүр, кофе шоп – худалдан авалтын түүх, байршил, төлбөрийн мэдээлэл
- CCTV камер – царай, дүрс, дуу хоолой

# БИДНИЙ ХУВААЛЦСАН МЭДЭЭЛЭЛ ЯМАР ЗАМЫГ ТУУЛДАГ ВЭ?

Бидний үлдээсэн өгөгдөл зүгээр алга болохгүй.  
Хаа нэгтээ хадгалагдаж, боловсруулагдаж,  
ашиглагдаж байдаг.





# ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЯМАР ЗОРИЛГООР АШИГЛАЖ БОЛОХ ВЭ?

Хувийн мэдээллийг хүний зөвшөөрөлд үндэслэн, хувь хүнийг танигдахгүй байдлаар нэгтгэн боловсруулж, нийгэмд хэрэгтэй судалгаа, шийдвэр гаргалтад ашиглах **үнэ цэнтэй мэдээлэл** бүтээж болно.



Хувийн мэдээллээ хуваалцах нь амьдралыг илүү хялбар, аюулгүй, үр дүнтэй болгоход хувь нэмэр оруулж болно.



# ГЭХДЭЭ ЭСРЭГЭЭРЭЭ, ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ АЛДАГДВАЛ ЯАХ ВЭ?

## → Аюулгүй байдлын эрсдэл

- Байршил болон өгөр тутмын гадлыг мэдэх
- Сошиал хаяг, төхөөрөмжиг зөвшөөрөлгүй нэвтрэх
- Мөрдөх, гарамтлах, сүргүүлэх

## → Санхүүгийн эрсдэл

- Банкны ганс, картын мэдээлэл алдагдах
- Хуурамч ганс, бүртгэл үүсгэх
- Цахим залилан, луйварт өртөх

## → Нэр хүнд, сэтгэлзүйн эрсдэл

- Хувийн зураг, мэдээллийг зөвшөөрөлгүй тараах
- Нэр хүндэд халгах
- Сэтгэлзүйн гарамт, айдас үүсэх

## → Нийгэм, харилцааны эрсдэл

- Ажил, сургууль, харилцаанг сөрөг нөлөө үзүүлэх
- Үл ойлголцол, ялгаварлан гадуурхалт үүсэх
- Нийгмийн оролцоо, боломж хязгаарлагдах

## → Мэдээллийн эрсдэл

- Хүсээгүй зар сурталчилгаа, tracking нэмэгдэх
- Улс төрийн нөлөөлөл ашиглагдах
- Хувийн мэдээлэлд тулгуурласан хэт чиглэсэн мэдээлэл, контентог өртөх

# ТЭГВЭЛ ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ХУВААЛЦАХ НЬ БУРУУ ЮУ?

Хувийн мэдээллээ хуваалцах үргэлж **буруу зүйл биш**.

Хамгийн чухал нь<sup>2</sup>

- хэнтэй
- ямар мэдээлэл хуваалцаж байгаа,
- юунд ашиглагдах,
- хаана хадгалагдах,
- хэр хугацаанд ашиглагдах
- цааш дамжуулагдах эсэхийг мэдэх, мэдээлэлтэй шийгвэр гаргах хэрэгтэй.

Хувийн мэдээллээ хамгаална гэдэг нь мэдээлэл өгөхөөс бүрэн татгалзахыг хэлэхгүй.

Харин болзошгүй эрсдэлээс сэргийлж, мэдээллээ **хэнд, хэрхэн, ямар зорилгоор өгөхөө ухаалгаар шийдэхийг** хэлнэ.

ЭРСДЭЭЛҮҮД

# ТАНЫ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ<sup>?</sup> ТА ЯМАР ЭРХ, ҮҮРЭГТЭЙ ВЭ?

Таны хувийн мэдээлэл  
таны өмч бөгөөд  
хуулийн дагуу та

“МЭДЭЭЛЛИЙН ЭЗЭН”.

## МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ЭРХҮҮД

### ЗӨВШӨӨРӨЛ ӨГӨХ

Мэдээллээ өгөх/  
өгөхөөс татгалзах



### МЭДЭЭЛЛЭЭ ЗАЛРУУЛАХ

Танг хамааралтай мэдээлэл  
алдаатай бол залруулах,  
шинэчлэх, нэмэлт мэдээлэл  
тусгуулах эрхтэй.



### НУУЦ

Хувийн мэдээллээ нууцлах



### МЭДЭХ

Таны хувийн мэдээллийг хэн, ямар  
зорилгоор цуглуулж байгаа, хэр  
удаан ашиглах, хэрхэн хамгаалах,  
бусдад дамжуулах эсэх зэргийг  
тодорхой мэдэх



### МЭДЭЭЛЛЭЭ УСТГУУЛАХ БУЮУ МАРТАГДАХ

Өөрийн хувийн мэдээллээ  
устгуулах эрхтэй.



### ГОМДОЛ/ТАЙЛБАР ГАРГАХ

Мэдээллийг боловсруулсны үр дүнд  
гарсан шийдвэрт гомдол, тайлбар  
гаргах, нэмэлт мэдээллийг оруулах,  
мэдээллийг дахин боловсруулахыг  
шаардах эрхтэй.



### ХҮССЭН ҮЕДЭЭ ЗӨВШӨӨРЛӨӨ ЦУЦЛАХ



### ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ХАМГААЛУУЛАХ

Та өөрийн хувийн  
мэдээллийг хууль бус  
цуглуулалт, ашиглалт,  
засруулалт, алдагдлаас  
хамгаалуулах эрхтэй.

## МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ҮҮРГҮҮД

Хэрэв та хувийн  
мэдээллээ хуваалцахаар  
шийгсэн бол<sup>?</sup>



Мэдээллийнхээ үнэн зөв  
байдлыг хангах



Алдаатай мэдээлэл  
байвал залруулах



Өөрийн мэдээллийг ашиглахдаа  
бусдын эрхийг зөрчихгүй байх  
үүрэгтэй

# ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ХУВААЛЦАХДАА ЮУГ АНХААРАХ ВЭ?

Орчин үед мэдээллээ огт өгөхгүй амьдрах бараг боломжгүй болсон. Банкны үйлчилгээ авах, хүргэлт захиалах, сургуульд бүртгүүлэх, сошиал сүлжээ ашиглах гээд өдөр бүр тодорхой хэмжээнд хувийн мэдээллээ хуваалцах шаардлага гарна.

→ Яагаад?

- Яагаад энэ мэдээлэл хэрэгтэй вэ? Ямар зорилгоор ашиглах вэ?

→ Хэн?

- Таны мэдээллийг хэн ашиглах вэ? Найдвартай, албан ёсны газар мөн үү?
- Танихгүй хүн, сэжигтэй сайт, дуудлагад мэдээллээ бүү өг!

Хувийн мэдээллээ хамгаалах нь мэдээллээ нуух тухай биш, харин “хэр хэмжээнд, ямар нөхцөлөөр өгөх вэ” гэдэгт оршино.

→ Ямар мэдээлэл?

- Таниас ямар мэдээлэл хүсэж байна вэ?
- Тухайн зорилгод үнэхээр шаардлагатай мэдээлэл мөн үү?
- Зөвхөн шаардлагатай хэмжээнд мэдээллээ хуваалц. Жишээ нь, хүргэлтийн үйлчилгээ үзүүлэхэд таны хаягийн мэдээлэл хэрэгтэй, харин регистрийн дугаар шаардлагагүй.

→ Хэрхэн?

- Таны мэдээллийг хэрхэн хадгалж, хамгаалах вэ?
- Гуравдагч этгээдэд дамжуулах уу?
- Та мэдээллээ засуулах, устгуулах боломжтой юу?

ЭРГЭЛЗЭЭТЭЙ  
САНАГДВАЛ “ҮГҮЙ”  
ГЭЖ ХЭЛЭХЭЭС БҮҮ  
САНАА ЗОВ.

Хэрэв зөвшөөрөл авахгүй, тайлбар мэдээлэл өгөхгүй бол тухайн байгууллага хүний хувийн мэдээлийн талаар ойлголт, бодлого сул байх магадлалтай. Ийм тохиолдолд таны мэдээллийг аюулгүй хамгаална гэдэгт бүрэн итгэхэд хүндрэлтэй.

# ТАНЫ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАЖ БУЙ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД ЯМАР ҮҮРЭГТЭЙ ВЭ?

## МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧИЙН ҮҮРЭГ<sup>2</sup>

Мэдээллийг ашиглах зорилго, нөхцөлийг ойлгомжтой тайлбарлаж, мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах

Зөвхөн шаардлагатай хэмжээнд мэдээллийг цуглуулах, ашиглах

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах

Мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байх

Мэдээллийг мэдээллийн эзний анх зөвшөөрсөн зорилгоос хэтрүүлж ашиглахгүй байх

Мэдээллийг зөвшөөрөлгүйгээр бусдаг дамжуулахгүй байх

Мэдээллийн эзэнд мэдээллээ шалгах, засах, устгуулах боломж олгох


Мэдээллийг ашиглаж дууссаны гараа зохих журмаар устгах

Мэдээллийн эзнээс зөвшөөрөл авахдаа **“МЭДЭЭЛЭЛТЭЙ ЗӨВШӨӨРӨЛ”** буюу гараах мэдээллийг өгсөний үндсэн дээр зөвшөөрөл авна<sup>2</sup>

- Мэдээлэл хариуцагчийн нэр
- Мэдээлэл ашиглах зорилго
- Ямар мэдээлэл авах
- Мэдээлэл боловсруулах, ашиглах хугацаа
- Мэдээллийг нийтэд ил болгох эсэх
- Мэдээллийг бусдаг дамжуулах эсэх
- Устгадаг, эсвэл хадгалах
- Зөвшөөрлийг цуцлах хэлбэр

Таны мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж буй этгээд бол **“МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧ”**.

# ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ХАМГААЛАХ ЗӨВЛӨМЖ



- Иргэний үнэмлэх, банкны карт зэрэг бичиг баримтаа бусдад өгөхгүй, ил харуулахгүй байх
- Олон нийтийн газар хувийн мэдээллээ чанга ярихгүй байх
- Хувийн мэдээлэлтэй цаас, баримтыг устгаж хэвших
- Хувийн мэдээллээ хуваалцахдаа зөвхөн шаардлагатай мэдээллийг өгөх

## ЦАХИМ ОРЧИНД

- Нууц үгээ хамгаалах
- 2 шатлалт баталгаажуулалт (2FA) идэвхжүүлэх
- Нууц үг, нэг удаагийн код зэргийг бусдад дамжуулахгүй байх
- Сэжигтэй линк, мессеж, файл нээхээс болгоомжлох
- Сошиал хаягийн нууцлал (privacy)-ын тохиргоогоо тогтмол шалгах
- Сошиал сүлжээнд хэт их хувийн мэдээлэл хуваалцахгүй байх
- Нийтийн компьютер, Wi-Fi ашигласны дараа аккаунтаасаа гарах
- Хувийн мэдээллээ хуваалцахдаа зөвхөн шаардлагатай мэдээллийг өгөх

Хувийн мэдээллээ хамгаалах нь мэдээллээ огт ашиглуулахгүй байх бус, харин өөрийн мэдээллийг ухамсартай, хяналттай ашиглан өөрийн аюулгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалах соёл юм.



ТунгдААХИ

- ӨТӨГДИЙН УРЛАН -